



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
Аудитын нэр: “Эрүүл мэндийн даатгалын сан,
тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн
дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн
байдал, үйл ажиллагаа” нийцлийн аудит
ҮАГ- НАГ/2014/09-НА/ХөААГ

ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан



**ТЭТГЭВРИЙН НЭРИЙН ДАНСАНД МӨНГӨН ХӨРӨНГӨ
БОДИТООР ХУРИМТЛАГДААГҮЙ БАЙНА.**

2014 оны 6 дугаар сар



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2014 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/31

Мө

**Аудитын тайлан баталгаажуулах
тухай**

МУ-ын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Нийцлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Эрүүл мэндийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн байдал, үйл ажиллагаа”-нд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний үр дүнг 2014 оны 12 дугаар сарын 01-ны дотор багтаан аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Дамдинсүрэн, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга П.Лхагважав нарт зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, аудитор /Ж.Отгончимэг/ нарт үүрэг болгосугай.

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ

My.Doc. Tushaal

07_031

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харъяа
Хөвсгөл аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Г.Оюунгэрэл

Аудитын менежер
Г.Эрдэнэчимэг

Аудитор
Ж.Отгончимэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70384043 дугаарын
утас, 70383793
дугаарын факсаар
харилцана уу?

ХАЯГ: (Хөвсгөл
аймгийн ЗДТГ-ын А
байр)

Цахим хаяг

www.khuvsgul-audit.mn

2014 оны 6 дугаар
сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

БҮЛЭГ 1.

1.1 Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан зарим нэгэн заавар, журам хэрэгжихгүй байна.

1.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөө 315,0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

1.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгүүдэд санхүүжилт олгож байна.

1.4 Эрүүл мэндийн даатгалын санд 2013 онд мэргэжлийн хяналт шалгалт хийгээгүй байна.

БҮЛЭГ 2.

2.1 Нэрийн дансыг хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу нээж ажилласан байна.

2.2 Нэрийн дансны орлогын эх үүсвэр хуулийн дагуу бүрдсэн ч өнөөгийн тэтгэврийн эх үүсвэр болсон байна.

2.3 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдах ёстой мөнгөн хөрөнгө бодитойгоор төвлөрөөгүй байна.

2.4 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд ямар нэгэн хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Хавсралт

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НЭ	Нэгдсэн эмнэлэг
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДСЗ	Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл
ТДШНД	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
НДТХ	Нийгмийн даатгалын тухай хууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМ	Эрүүл мэнд
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллагууд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ИЭМДТ	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дор дурьдсан зорилтын хүрээнд шалгаж, дүгнэлт гарган санал зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн даатгал нь: холбогдох хууль, түүнийг дагаж мөрдөх журмын дагуу явагдаж /хэрэгжиж/ байгаа эсэх /даатгалын шимтгэл төлсөн, даатгалын санг урьдчилан бүрдүүлсэн, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг төлсөн байдал/
- ✓ Тэтгэврийн даатгал нь: Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмын дагуу явагдаж /хэрэгжиж/ байгаа эсэх /даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн дансны тэтгэвэр тогтооход бэлэн эсэх/
- ✓ Сангуудын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалттай, үр нөлөөтэй эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитаар ЭМГ, СТСХ, НДХ, НЭ болон бусад байгууллагуудын эрхлэн хариуцаж буй нийгмийн даатгалын сангийн бүрэлдэхүүн хэсэг болох Эрүүл мэндийн даатгалын сангийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт шалгалтын байдал, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн орлого, хүү /хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн/ тооцоололтын байдал бодитой эсэхийг 2013 оны байдлаар хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан зарим тусгай сангийн ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажилласан.

Баримт бичгийн судалгаа:

- ✓ Эрх зүйн баримт бичгүүд, байгууллагын 2014-2015 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, дотоод журам, бүтэц орон тоо, зарим нэгэн ажилтан албан хаагчдийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ зэргийг судлан

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө болон ЭМДаатгалын сангийн үйл ажиллагааны чиглэл, удирдлага болон шийдвэр гаргах, хэрэгжүүлэх тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлохыг зорьсон.

- ✓ НДХэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайланг уншиж судалсан.
- ✓ Аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Тэргүүлэх аудиторoor батлуулан холбогдох албан тушаалтнуудад танилцуулан албан ёсоор гардуулсан.
- ✓ Дээрх сангуудын албан ёсны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, эмхэтгэл, анхан шатны баримтууд зэргийг судалгаа, шинжилгээний мэдээлэл болгон ашигласан.
- ✓ Нэрийн данс болон ЭМДСангийн талаарх мэдээ, мэдээлэл, үйл ажиллагаа нь холбогдох хуульд заасан үндсэн зорилгод хир нийцэж буйд үнэлгээ хийсэн.
- ✓ Холбогдох ажилтан албан хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, асуулга тодруулга авч ажилласан.
- ✓ Нэрийн данс, эрүүл мэндийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны, санхүүгийн тайлан мэдээ болон бусад холбогдох баримт бичгийг эх сурвалжийн зөвшөөрснөөр хуулбарлан авсан.
- ✓ Хэлтсийн зарим нэгэн ажилтан албан хаагчдаас тухайн үйл ажиллагааг явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийн өнөөгийн байдал / *ялангуяа орон нутагт үйл ажиллагаа явуулахад зөрчилдөж буй хууль эрх зүй* /, тэд хэрхэн үнэлдэг болох талаар ярилцлага авсан.
- ✓ Сүлжээ зохицуулагч, нэрийн данс, сургалт хариуцсан болон ЭМДаатгалын сангийн зарлага хариуцсан мэргэжилтэн, НДШимтгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж байсан мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулан, тэд сангийн зорилгыг бүрэн ойлгон ухамсарласан эсэх, өөрсдийн гүйцэтгэлд хэрхэн сэтгэл хангуулан байдагт тандалт, судалгааг хийсэн.
- ✓ Хэлтсийн даргатай удаа дараа уулзаж, санал бодлоо солилцож ажилласан.
- ✓ Цэргийн тэтгэвэр авагчдийн хувийн хэрэгт /1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн/ дотоод хяналтын байцаагчийн хамт үзлэг шалгалт¹ хийж тэтгэврийн байцаагч А.Амараар 83 хувийн хэрэгт шалгалт хийлгэн түншлэлийн “Үнэлгээ” хийлгэсэн.
- ✓ Сангийн 2013 оны санхүүгийн тайланд тулгуурласан. НА-4200 стандартыг баримталсан. /*ТАБ-аар баталгаажуулсан*/
- ✓ Хэлтсийн дотоод хяналтын байцаагчтай уулзаж, дотоод хяналтын журам, 2013 оны хяналтын тайлан болон бичиг баримтыг шалгаж, санал бодлоо солилцсон.
- ✓ Аудитын явцад илэрсэн аливаа алдаа зөрчлийг арилгах талаар ам зөвлөмж өгч ажилласан.

Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- ЗГ-ын тусгай сангийн тухай хууль
- Төрийн нууцийн тухай хууль
- Байгууллагын нууцийн тухай хууль
- Хувь хүний нууцын тухай хууль

¹ ТДШимтгэл хариуцсан 3 байцаагчийн хувийн хэргийг түүвэрлэн 6 өндөр настны тэтгэвэр тогтоолтыг шалгасан
[УАГ-НАГ/2014/09-НА/-ХӨААГ](#)

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоол
- Нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай НДҮЗөвлөлийн тогтоолууд
- Засгийн газар, НДҮЗ, ЭМДСалбар зөвлөлийн холбогдох тогтоол, шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Аудитын газрын тэргүүлэх аудитор Г. Оюунгэрэл хянан удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг, аудитор Ж.Отгончимэг нар гүйцэтгэж, тайлагнав.

Эрүүл мэндийн даатгалын сан

Бүлэг 1 *Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан зарим хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.*

Ерөнхий зүйл:

Эрүүл мэндийн даатгалын санд 2013 онд 3541,4 сая төгрөг төвлөрч төлөвлөсөн хэмжээнээс 313,3 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй улсын болон хувийн хэвшлийн 13 эмнэлэг, 1 рашаан сувилал, 27 эмийн сантай гэрээ байгуулан 3526,3 сая төгрөгийн санхүүжилт олгон ажилласан байна.

ЭМДСангийн хөрөнгийн 2013 оны зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг хэлтсийн дарга П.Лхагважав, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг, Ц.Бурмаа нар зурж, сангийн орлого, зарцуулалтыг Төрийн сан, Төрийн банк, ХААН банкаар дамжуулан гүйцэтгэсэн байна.

1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан зарим хууль тогтоомж хэрэгжихгүй байна.

1.1.1 Аймгийн эрүүл мэндийн даатгалын орон тооны бус зөвлөл ажиллахгүй байна.

ИЭМДТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 заалт “Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлд орон тооны бус салбар зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг даатгалын зөвлөл батална” заалтын дагуу Хөвсгөл аймгийн ЗД-ийн 2009 оны 02 дугаар сарын 09-ны “Салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” 50 дугаар захирамж гарч аймгийн салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтнийг томилсон байна.

Гэсэн хэдий ч Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн даатгалын орон тооны бус зөвлөл 2012 оноос хойш хуралдаагүй, ямар нэгэн асуудал шийдвэрлээгүй байна.

1.1.2 Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс хуульд заасан чиг үүргийн дагуу ажиллаж байна

ИЭМДТхуулийн 5.1-д Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан нэгжийн чиг үүргийн хэрэгжилт дараах байдалтай байна.

5^{1.1.1}. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад сурталчлах ажлыг зохион байгуулж “Эрх чөлөө”, “Далай ээж” сонинд

мэдээлэл гарган, “Чандмань”, “Хөвсгөл” телевизээр мэдээлэл хийн, “Нийгмийн даатгалын байгууллага”-ын нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж 2013 онд 14 сумын 126 ажил олгогч, мөрөн сумын 278 ажил олгогчид нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжоор зааварчлага өгч ажилласан байна.

ИЭМДТхуулийн 5.1.2 заалтын хүрээнд: “Эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэх, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах, үйл ажиллагаагаа даатгалын зөвлөлд тайлагнах” чиг үүргийн хүрээнд:

- Эрүүл мэндийн даатгалын санд 2013 онд эрүүл мэндийн даатгалын 3275,8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 3541,5 сая төгрөгийн орлого шимтгэл бүрдүүлэн батлагдсан төлөвлөгөөг 265,7 сая төгрөгөөр давуулан гүйцэтгэлийг ханган ажиллаж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд 2013 оны үйл ажиллагаагаа тайлагнасан байна.

ИЭМДТхуулийн 5.1.3 заалтын хүрээнд: Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагатай даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэх чиг үүргийн хүрээнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа төрийн өмчит 5 сум дундын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн 7 эмнэлэг, 1 рашаан сувиллын газартай
- ЭМДСангаас даатгуулагчид зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх 23 сумын эмийн эргэлтийн сан, хувийн хэвшлийн 4 эмийн сантай гэрээ байгуулан ажилласан байна.

НДҮЗөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан ЭМДСангийн тодотгосон төсвийн дагуу эмийн сангуудтай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна. **Тухайлбал: 18 сумын эмийн эргэлтийн сан, хувийн хэвшлийн 4 эмийн сантай хийсэн гэрээ тодотгосон төсвөөс 800,0 мянган төгрөгөөс 18000,0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.**

Аймгийн НДХэлтэс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах байгууллагуудтай байгуулсан гэрээний 3.2 заалтын дагуу тусламж үйлчилгээний жагсаалтыг хянан, нягтлан шалгаж ажилласан байна. 2013 онд НДХэлтсийн эрүүл мэндийн улсын байцаагчийн хяналтаар илрүүлсэн /нэр давхардсан, шимтгэл төлөөгүй, үйлчилгээ давхардсан, нэр регистр, оношны зөрүүтэй гэх мэт/ зөрчил 140884,3 мянган төгрөг байна.

ЭМДСангийн хөрөнгөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагууд болон даатгуулагчид зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн эмийн сангуудтай байгуулсан гэрээг дүгнэхдээ НДЕГазрын даргын 2012 оны А/367 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1-д заасан баг, бүрэлдэхүүнээр гэрээ дүгнээгүй байна.

Гэрээний биелэлт хангалтгүй дүгнэгдсэн эрүүл мэндийн байгууллагын жагсаалт:

ЭМБ-ын нэр	Гэрээний хэрэгжилтийн ерөнхий дүн	Журмын дагуу цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Хатгал СДЭ	58	Журмын 5.1.4 заалтаар гэрээг шууд цуцална. Журмын 5.1.2 заалтаар алдаа дутагдлаа арилгах талаар албан шаардлага хүргүүлэх, албан шаардлагын биелэлтийг үндэслэн
Бүрэнтогтох ЭЭС	70	
Галт ЭЭС	74	
Ренчинлхүмбэ ЭЭС	71	

Цагаан уул ЭЭС	76	цаашид гэрээ сунгах эсэхийг шийднэ.
Цагаан нуур ЭЭС	78	
Цагаан үүр ЭЭС	75	
Цэцэрлэг ЭЭС	78	
Түнэл ЭЭС	76	
Эрдэнэбулган ЭЭС	78	

Гэрээ дүгнэхэд хангалтгүй үнэлэгдсэн эмийн эргэлтийн сангуудад алдаа дутагдлаа арилгах талаар ЭМДУлсын байцаагч албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

5.1.4.өвчин, эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн дагуу даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих чиг үүргийн хүрээнд:

Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах чиглэлээр эмнэлгийн чанарын албатай хамтран ажилласан бөгөөд 2013 онд тусламж үйлчилгээний чанартай холбоотой ямар нэгэн төлбөр зөрчил илрээгүй байна.

5.1.5. эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх чиг үүргийн хүрээнд:

Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардалд 3550795,1 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс гэрээ бүхий эмнэлэг, эмийн сан, сувилалд 3526311,9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

5.1.6.эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх чиг үүргийн хүрээнд:

Аймгийн НДХэлтээс ИЭМД-тай холбоотой дараах саналыг НДЕГазарт хүргүүлсэн байна.

- Эрүүл мэндийн даатгалыг өрхийн даатгалд шилжүүлж, өөрөөр хэлбэл ам бүлийн эхнэр хүүхдийн аль нэгний өмнөөс ЭМД төлөх боломжоор хангаж өрхийн даатгалыг бий болгох
- Хувийн, улсын эмнэлгийг ялгалгүй ЭМД санхүүжилтийг олгодог болгож, даатгуулагчдаас авдаг төлбөрийг нэг мөр болгох
- Өрхийн болон сумдын анхан шатны эмнэлгийн ЭМД-аар санхүүжүүлдэг болох. Учир нь сумдын иргэд ЭМД төлдөг боловч 2,3 дугаар шатлалын эмнэлэгт явахад ЭМД үйлчилгээ авдаг, эмийн хөнгөлөлтөөс өөр даатгалын үр дүн хүртэхгүй байна.
- Даатгуулагчийг өөрийн сонгосон эмнэлэг, эмийн сангаас үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх
- ЭМДШимтгэл төлөөд даатгалын үйлчилгээ аваагүй иргэдийн урамшууллын хэлбэрийг олон болгох
- ЭМД төрөөс төлж байгаа хэмжээг нэмэгдүүлэх
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг байх
- ЭМД дэвтрийг цахим дэвтэр болгох

- Гадаад оронд эмчлүүлсэн, мэс засал хийлгэсэн тохиолдолд ямар нэгэн хэлбэрээр тодорхой хувийг ЭМДСангаас олгодог болох

1.1.3 Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуультай холбогдуулан гарсан дараах журмын хэрэгжилт хангалтгүй байна.

- НДҮЗ-ийн 2007 оны 06 тоот тогтоолоор батлагдсан Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.3 дахь заалтыг үндэслэн эрүүл мэндийн даатгалын сангийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын болзошгүй эрсдлийн нөөцөд үлдээж байх журам
- Аймаг, нийслэлд ЭМД-ийн орон тооны бус салбар зөвлөл ажиллах журам
- Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн олгох тухай журам

1.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөө 315,0 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Даатгуулагчийн төлөх ЭМДШимтгэлийн 2013 оны тодотгосон төлөвлөгөө 1373342,2 мянган төгрөг бөгөөд 1579080,4 мянган төгрөг төвлөрүүлж шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 14,9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Ажил олгогчийн төлөх ЭМДаатгалын шимтгэлийн хэмжээг 2013 онд НДҮЗ- өөс 2 хувиар тогтоож 1238089,0 мянган төгрөгийн төлөвлөгөө хуваарилагдсан байна. Аймгийн НДХэлтэс 897² аж ахуйн нэгж байгууллагаас 1348058,0 мянган төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн байна.

Аймгийн НДХэлтэс 2013 оны жилийн эцсийн байдлаар дараах ААНБайгууллагуудаас НДШимтгэлийн ихээхэн хэмжээний авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд:

ААНБ-ын нэр	Авлагын дүн /мян,төг/
Хөвсгөл ус чандмань ОНӨҮГазар	106870,0
Цөм сүргийн аж ахуй ТӨҮГ	3698,9
Хөвсгөл авто зам арчлалт ТӨҮГ	29751,8
Урагшлах ХХК	11071,9

Төр даатгалыг хариуцах иргэний ЭМДШимтгэлд 2013 онд 600588,0 мянган төгрөг олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 600588,0 мянган төгрөгийг 64558 иргэний ЭМДаатгалд төрөөс хариуцан төлсөн байна. Даатгалын зардлыг НДЕГазраас батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлсэн байна.

ЭМДСангийн чөлөөт үлдэгдлийг 2013 оны жилийн эцэст НДЕГазрын даргын 2013 оны А/90 тоот “Нийгмийн даатгалын сангийн төсвийн хөрөнгийн менежментийг

² 897 ААНБ нь тус хэлтэст бүртгэлтэй /өр/авлага/ бөгөөд 836 ААНБайгууллага нь шимтгэл төвлөрүүлсэн байгууллага болно.

сайжруулах тухай” тушаалын дагуу 614,0 сая төгрөгийг улсын нэгдсэн санд татан төвлөрүүлсэн байна.

1. ЭМДСангийн хөрөнгийн байршлыг банкаар харуулбал:

/Мянган төгрөгөөр/

№	Банкны нэр	Орлогын дүн	Зарлагын дүн	Үлдэгдэл	Хүүгийн орлого
1	Төрийн сан банк	4876021,4	5155220.6	35250.8	
2	Төрийн банк	48340.7	34948.8	13391.9	92,4
3	ХААН банк	550316.8	532915.0	67802.5	2769.6
	Дүн	5474678.9	5723084.4	116445.2	2861,1

ЭМДСангийн арилжааны банкн дахь чөлөөт үлдэгдэлд 2861,1 мянган төгрөгийн орлого олсон байна.

ЭМДСангийн орлогын журнал шалгахад ИЭМД тухай хуулийн 111 заалтыг зөрчиж хугацаа хэтрүүлэн шимтгэл төлсөн байгууллагууд байна. **Тухайлбал:**

- Аймгийн прокурорын газар, Хот тохижилт үйлчилгээний төв, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хүүхэд, гэр бүлийн хэлтэс, Мөрөн сумын 9 р цэцэрлэг, Гурван эрдэнэ сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Ус чандмань ОНӨҮГ, Хөвсгөл АЗЗА ТӨҮГ, Цөм сүргийн аж ахуй ТӨҮГ, Урагшлах ХХК

НДШимтгэл төлөх хугацаа хоцроосон дээрх байгууллагуудад НДХэлтсийн улсын байцаагчид ИЭМД тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1³-д зааснаар хариуцлагын арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн хэмжээгээр 2013 онд шимтгэл дутуу төлсөн 30 ажил олгогчийн 87 даатгуулагчтай холбоотой 2,8 сая төгрөгийн нөхөн төлбөр, алданги ногдуулж ЭМДШ-ийн санд төвлөрүүлэн ажилласан байна.

1.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгүүдэд санхүүжилт олгож байна.

1.3.1 Аймгийн Нэгдсэн эмнэлэг хувийн эмнэлгүүдийн лабораторийн шинжилгээний төлбөрийг ЭМДСангаас гаргуулж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг 2014 онд хувийн эмнэлгүүдтэй үйл оношийн шинжилгээ хийх тухай хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээнд “Үйл оношийн тасагт багажийн болон лабораторийн шинжилгээ хийлгэсэн тохиолдолд нэгжийн өртгөөр шинжилгээний төлбөр авах тухай” заасан нь МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2009 оны

³ 15.1. Аж ахуйн нэгж, байгууллага, ерөнхий менежер даатгалын шимтгэлийг энэ хууль болон даатгалын гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй бол уг шимтгэлийг нөхөн төлүүлж, хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих хураамжийн 0.3 хувьтай тэнцэх алданги даатгагчид төлнө. Хэрэв хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь тогтоогдсон бол гэм буруутай этгээдээр нуусан, бууруулсан орлогод ногдох шимтгэлийг нөхөн төлүүлж, мөн орлоготой тэнцэх хэмжээний алданги ногдуулна.

180 дугаар тушаалаар батлагдсан “ЭМДСангаас санхүүжих тусламж үйлчилгээний төлбөрийн арга, санхүүжилтийн хэмжээг тооцох журам”-ын 5 дугаар заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна. Иймд: аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга С.Чагнаадоржид хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран ажиллах тухай байгуулсан гэрээгээ эргэн харж өөрчлөх “Албан шаардлага” хүргүүлж байна.

1.3.2 Эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийн хуваарилалтыг даатгуулагчдад ойр, тэгш хүртээмжтэй байхаар хуваарилахгүй байна.

ИЭМДТухай хуулийн 12.9 заалт, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2011 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын дагуу аймгийн нийгмийн даатгалын хэлтэс эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зөвшөөрөл бүхий 27 эмийн сантай гэрээ байгуулан нийт 3526163,4 мянган төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэн ажилласан байна.

Хатгал тосгоны Эмийн эргэлтийн санд эмийн үнийн хөнгөлөлтийн журмын хэрэгжилтийн байдлыг хянаж шалгахад дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 6 дугаар сар, 7 дугаар сард олгох хөнгөлөлттэй эмийн олголт хийгдсэн
- Эмчийн кодгүй жороор эм олгосон
- Ерөнхий эмчийн нэрийн тэмдэг бүхий жорын бичгээр бусад эмч нар эм олгосон
- Статистикч эмч болон бага эмч нар хөнгөлөлттэй эмийн жор бичсэн
- Бар кодын машинаар гаргаж байгаа кассын тасалбарыг зөвхөн НДаатгалаас санхүүжилт, хөнгөлөлт авахад зориулан ашиглаж байгаа
- 2013 онд хөнгөлөлт авсан эмийн жоронд кассын тасалбаргүй

Эмийн сангуудтай байгуулсан гэрээний 4.4 “Эмийн сан нь даатгуулагчтай эмийн үнийн төлбөр тооцоог кассын болон бар кодын машинаар хийж, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн даатгуулагчдад эм авсан тухай бүрд нь кассын эсхүл баркодын машины тасалбарын нэг хувийг заавал олгоно” заалт хэрэгжихгүй байгаа нь аймгийн ЭМГазрын хийсэн судалгаа, аудитад хамрагдсан эмийн сангуудын үйл ажиллагаагаар нотлогдож байна. Үүнд: аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, байцаагчид хяналт тавьж, зөвлөгөө өгч шаардлага хүргүүлж ажилласан боловч тодорхой үр дүн гараагүй байна. Учир нь: Тухайн ЭЭСанд ажиллаж буй ажилтан албан хаагчдийн программ хангамж, /цахим хэлбэрээр/ компьютер дээр ажиллах чадвар хангалтгүй байна. Мөн сумдын ажилтан албан хаагчдийн тухайд интернетийн орчин /цахим сүлжээ/ байхгүйгээс шалтгаалж дээрх зөрчил үүсч байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар 2013 онд хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ шинээр үзүүлэх эмийн сангуудад сонгон шалгаруулалт явуулаагүй бөгөөд урьд онуудад үйлчилж байсан эмийн сангуудын нэрсийг аймгийн НДХэлтэст ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн төв Мөрөн суманд хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эрх бүхий 4 эмийн сан ажиллаж байгаа хэдий ч зардлын хуваарилалт харилцан адилгүй байна.

Аймгийн төвд 36 мянга гаруй иргэн 13 багт амьдарч байхад 4 эмийн сан ажиллаж байгаа нь даатгуулагч иргэд эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ ойртож, тэгш, хүртээмжтэй болж чадахгүй байна.

№	Эмийн сангийн нэр	Байршил	Батлагдсан төсөв /мян,төг/	Нийт хөнгөлөлтөд эзлэх хувь
1	Хөвсгөл эм хангамж	5 р баг	122722,9	56,7
2	Марал од гариг	5 р баг	66000,0	30,5
3	Эм увидас	4 р баг	14000,0	6,4
4	Алтан өргөө	2 р баг	14000,0	6,4
Нийт хөнгөлөлтийн дүн			216722,9	100,0

1.3.3 Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгүүдэд ЭМДСангаас санхүүжилт олгож байх чиглэлийг НДҮЗ өгсөн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 418 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн 8 эмнэлгийг шалгаруулж, Эрүүл мэндийн яаманд үр дүнг тайлагнасан боловч магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгийг сонгон шалгаруулсан байна. **Тухайлбал:**

№	Эмнэлгийн нэр	Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа	Зөрчилтэй олгосон санхүүжилт
1	Жаргалан	2013-10-01	14056,8
2	Цээнэ	2013-10-01	17246,4
3	Энх-үрс	2013-10-01	15926,1
4	Мөнхтулгуур	2013-10-01	14280,0
5	Олонд туслах	2013-04-15	18216,6
Дүн			79725,9

Нийгмийн даатгалын байгууллага нь ЗГ-ын 2008 оны 172 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 200 дугаар тушаалд заасан шалгуур үзүүлэлт болох магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДСангаас 2013 онд 79725,9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

НДЕГазрын харьяа ЭМДГазрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 04-ны өдрийн 1/34 албан тоотоор магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгүүдэд даатгуулагчдад үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг гүйцэтгэж байх нь зөв гэсэн шийдвэр өгсөн нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлгийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг үгүйсгэсэн шийдвэр болсон байна. Энэ нь тухайн ажлыг хариуцан ажиллаж буй төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Аймгийн НДХэлтэс гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ИЭМДТхүүлийн 12 дугаар зүйлийн 12.2 заалтын дагуу ЭМДСангаас санхүүжилт олгож ажилласан байна. Гэсэн хэдий ч гэрээнд зааснаас 74702,8 мянган төгрөгөөр илүү буюу төсвийн хуваарийн дагуу санхүүжилт олгосон байна.

ЭМДаатгалын сангаас ЭМТҮйлчилгээнд олгосон санхүүжилтийн судалгааг /Хүснэгт-1/ ээс харна уу?

Хүснэгт-1

/мянган төгрөгөөр/				
Хувийн хэвшлийн эмнэлгийн нэр	Тодотгосон төсөв	Гэрээний дүн	Санхүүжүүлсэн дүн	Зөрүү дүн /гэрээ-санхүүжүүлсэн/

Улаан уул СДЭ	14063,9	14063,9	14062,3	0,0
Хатгал СДЭ	13243,1	13243,1	13243,3	0,0
Цагаан уул СДЭ	13252,6	13252,6	13252,3	0,0
Шинэ идэр СДЭ	13211,3	13211,3	13208,4	0,0
Их уул СДЭ	13686,4	13686,4	13681,1	0,0
Нэгдсэн эмнэлэг	2542 884,2	2542 884,2	2542 546,8	0,0
Төрийн өмчийн Эмнэлгийн дүн	469395,7	2610341,5	2609994,2	0,0
Олонд туслах эмнэлэг	64597,5	64597,5	64597,4	0,0
Эрх үрс	56475,7	56475,7	56475,7	0,0
Мөнхтүлгүүр	50638,5	50638,5	50637,3	0,0
Цээнэ	61157,3	61157,3	61157,3	0,0
Отос намнан	62989,7	62989,7	62989,7	0,0
Жаргалан	49846,5	49846,5	49846,5	0,0
Ренчинжугнай	123690,6	123690,6	100704,4	0,0
Хувийн хэвшлийн ЭМБ- ийн дүн	469395,7	469395,7	446408,3	
Галтын халуун ус рашаан сувилалын дүн	79920,0		79920,0	
Алаг Эрдэнэ ЭЭС	3800,0	3800,0	3800,0	0,0
Арбулаг ЭЭС	5200,0	5200,0	5200,0	0,0
Баянзүрх ЭЭС	10600,0	8000,0	10600,0	2600,0
Бүрэнтогтох ЭЭС	4000,0	4000,0	4000,0	0,0
Галт ЭЭС	13500,0	8700,0	13500,0	4800,0
Жаргалант ЭЭС	11900,0	9000,0	11900,0	2900,0
Их уул ЭЭС	10050,0	8000,0	10050,0	2050,0
Рашаант ЭЭС	10250,0	8000,0	8952,8	952,8
Ренчинлхүмбэ ЭЭС	3500,0	3500,0	3500,0	0,0
Төмөрбулаг ЭЭС	10000,0	7500,0	10000,0	2500,0
Тосонцэнгэл ЭЭС	9450,0	7000,0	9450,0	2450,0
Тариалан ЭЭС	12450,0	10000,0	12450,0	2450,0
Улаан уул ЭЭС	7500,0	7500,0	7500,0	0,0
Хатгал ЭЭС	8100,0	6600,0	8100,0	2500,0
Ханх ЭЭС	4500,0	4000,0	4500,0	500,0
Цагаан уул ЭЭС	9900,0	8000,0	9900,0	1900,0
Цагаан нуур ЭЭС	4000,0	3200,0	4000,0	800,0
Цагаан үүр ЭЭС	2365,0	1565,0	2365,0	800,0
Цэцэрлэг ЭЭС	9450,0	7000,0	9450,0	1450,0
Чандмань өндөр ЭЭС	6950,0	5500,0	6950,0	400,0
Түнэл ЭЭС	5950,0	4500,0	5950,0	1450,0
Шинэ идэр ЭЭС	6500,0	5000,0	6500,0	6500,0
Эрдэнэбулган ЭЭС	4500,0	2800,0	4500,0	1700,0
Марал од гариг ЭЭС	66000,0	48000,0	66000,0	18000,0
Хөвсгөл эм хангамж ЭЭС	122722,9	106722,9	122722,9	16000,0
Эм увидас ЭЭС	14000,0	13000,0	14000,0	1000,0
Алтан өргөө ЭЭС	14000,0	13000,0	14000,0	1000,0
Эмийн сангийн дүн	391137,9	319087,9	389840,6	74702,8

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын санхүүгийн баримтыг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- НДХэлтсийн “**санхүүгийн ажилтнууд**” гэрээний 3.6 заалтын дагуу улирал бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй
- Гэрээний 4.5-д зааснаар сар бүрийн 20-ны өдрөөр ЭМТҮ-г тасалбар болгоогүй хугацаа хэтэрсэн зардлыг санхүүжүүлсэн
- Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлыг эмнэлгийн байгууллагад сарын хуваарийг үндэслэн урьдчилан төлж, гүйцэтгэлээр дараа сарын 25-ны дотор тэр бүр олгож чадаагүй байна.

1.3.3 Энэ хуулийн 5.4, 7.8, 9.4, 9.3, 12.14 дэх хэсэгт тус тус заасан зардлууд хуулийн дагуу санхүүжүүлсэн эсэх

ИЭМД тухай хуулийн 5.4 заалт: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан даатгалын зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, даатгалын зөвлөлийн ажиллах журмыг талуудын саналыг үндэслэн батална. Даатгалын зөвлөлийн дарга, гишүүдэд ажлын оролцоог харгалзан урамшуулал олгож болно. ИЭМДТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 заалт “Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлд орон тооны бус салбар зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг даатгалын зөвлөл батална.”

Заалтын дагуу Аймгийн Засаг даргын 2009 оны 50 дугаар захирамж гарч аймгийн орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан боловч 2012 оноос хойш НДҮЗөвлөлийн тогтоолоор батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулаагүй тул 2013 онд урамшуулал олгоогүй байна.

ИЭМД тухай хуулийн 7.8 заалт: Дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж урамшуулах бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

Эрүүл мэндийн даатгалын сангаас ИЭМДТхуулийн 7.8 заалтын дагуу 2013 онд 4012,8 мянган төгрөгийг урамшууллыг аймгийн нэгдсэн эмнэлэгт олгохоор гэрээ хийж, 168 даатгуулагчийн 3696,0 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсныг 4012,8 төгрөгөөр буюу гүйцэтгэлээс 316,8 мянган төгрөгийг илүү олгосныг ЭМДаатгалын улсын байцаагч төлбөрийн акт тогтоон ажилласан байна.

ИЭМД тухай хуулийн 9.4 заалт: Эрүүл мэндийн даатгалын сангийн хэмнэгдсэн үлдэгдлийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдгээрийн хүртээмж, хамралыг нэмэгдүүлэхэд зарцуулж болно.

ЭМДСангийн хэмнэгдсэн үлдэгдлийг хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдгээрийн хүртээмж, хамралыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зарцуулах тухай НДҮЗ-өөс шийдвэр гаргаж орон нутгийн НДБайгууллагад ирүүлээгүй байна.

ИЭМД тухай хуулийн 9.3 заалт: Эрүүл мэндийн даатгалын сангийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг болзошгүй эрсдлийн нөөцөд үлдээж болох бөгөөд түүнийг зарцуулах журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

Аймгийн НДХэлтэст “Болзошгүй эрсдлийн сан” байгуулагдаагүй байна.

ИЭМД тухай хуулийн 12.14 заалт: “Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн олгож болох бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална”

Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан 2013 онд санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн олгоогүй байна.

1.3.4 ЭМДСангийн хөрөнгийг болзошгүй эрсдлийн нөөцөд үлдээж байна уу?

Болзошгүй эрсдлийн сан байгуулагдаагүй тул санд хөрөнгө үлдээх боломжгүй байна.

1.3.5 ЭМДСангийн хэмнэгдсэн үлдэгдлийг хуулийн дагуу зарцуулж байна уу?

ЭМДСангаас 2013 оны жилийн эцсийн дансны үлдэгдлээс нийт 314000,0 мянган төгрөгийг НДЕГазарт татан төвлөрүүлж 116445,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Огноо	Дүн
2014-12-25	140,000.0 мянган төгрөг
2014-12-30	88,000.0 мянган төгрөг
2014-12-31	86,000.0 мянган төгрөг
Бүгд дүн	314,000.0 мянган төгрөг

ЭМДСан 2013 онд

- Орлого 3541491,1 мянган төгрөг
- Зарлага 3526312,0 мянган төгрөг
- Хэмнэгдсэн үлдэгдэл 15179,0 мянган төгрөг байна.

1.4 Эрүүл мэндийн даатгалын санд 2013 онд мэргэжлийн хяналт шалгалт хийгээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч 2013 онд дараах хяналтыг хийсэн байна. **Үүнд:** Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн зардлын нэхэмжлэлийн үндсэн баримт болох өвчний түүх, жортой тулган шалгаж хувийн хэвшлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн иргэдийн **50** орчим хувь буюу **2000** хүнтэй нь утсаар, 1100 хүнээс сэтгэл ханамжийн судалгаа авч хувийн хэвшлийн Олонд туслах эмнэлэг, Эм импекс, Марал од гариг, Эм увидас эмийн сан, сумдын эргэлтийн эмийн сангуудад шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна. Мөн **2013** онд Нэгдсэн эмнэлэгт **1817.1**, Хатгал СДЭ-т **999.7** Их уул СДЭ **668.4**, Жаргалан ХХЭ т **600.7** төгрөгийн акт бичиж бүрэн барагдуулан ажилласан байна. Хяналт шалгалтаар Даатгуулагчийн эрх ашгийг хохироосон, даатгуулагчаас нэмэлт төлбөр авсан зэрэг зөрчил илрээгүй байна.

Хөвсгөл аймгийн тухайд 168000 даатгуулагч, 836 ажил олгогч, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаг 39 байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд 1 /их эмч мэргэжлийн/ улсын байцаагч ажиллаж байгаа нь ажлын ажлын ачаалал ихдэж, хяналт тавихад ажлын цар хүрээг хязгаарлахад хүргэж байна.

Харин ЭМДСанд 2013 онд аймгийн Мэргэжлийн хяналт хяналт шалгалт хийгээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2009 оны 02 тоот захирамжаар томилогдсон Эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөл орон нутагт хуулийн хэрэгжилтийг хангаж, сангийн зарцуулалтанд хяналт тавих, чиг үүргийн дагуу ажиллахгүй байна.
2. Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс ЭМДСангийн орлогыг хангалттай бүрдүүлж байгаа хэдий ч НДШимтгэл төлөх хугацаа хоцроосон ААНБбайгууллагад ИЭМД тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар хариуцлагын арга хэмжээ авч ажиллаагүй байна
3. ЭМДСангийн хөрөнгөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагууд болон даатгуулагчид зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн эмийн сангуудтай байгуулсан гэрээг дүгнэхдээ НДЕГазрын даргын 2012 оны А/367 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1-д заасан баг, бүрэлдэхүүнээр дүгнээгүй байна
4. Эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийн хуваарилалтыг даатгуулагчдад ойр, тэгш хүртээмжтэй байхаар сонгон шалгаруулж хуваарилаагүй байна.
5. НДҮЗөвлөлөөс магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгүүдэд эрүүл мэндийн үйл ажиллагааны зардлын санхүүжилт олгох чиглэл өгсөн нь тухайн ажлыг хариуцан гүйцэтгэж буй ажилтан албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.
6. ЭДСангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын хэрэгжилт эмийн сангуудад хангалтгүй, бар кодын машин, программ хангамжийн ашиглалт муу байна.
7. Хөвсгөл аймгийн тухайд: Хүн ам, ААНБ болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаг байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж олон тул эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд 1 /их эмч мэргэжлийн/ улсын байцаагч ажиллаж байгаа нь ажлын ачаалал их, хяналт тавих ажлын цар хүрээг хязгаарлахад хүргэж байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

НДҮЗөвлөлийн дарга С.Эрдэнэ-д

1. Эрүүл мэндийн даатгалтай холбоотой гарсан зарим заавар, журмыг орон нутагт хэрэгжүүлэх боломж нөхцөл олгож хэрэгжилтийг хангуулан ажиллах
2. Орон нутгийн орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах журам, нөхцлийг тодорхой болгон шийдвэр гаргах
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүдийн магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрлийн хугацааг харгалзан ЭМДСангаас санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэж байх
4. Орон нутгийн хүн ам, даатгуулагчийн тоо, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цар хүрээг харгалзан үзэж, эрүүл мэндийн даатгалын сангийн улсын байцаагчийн ажлын ачааллыг зохицуулан бүтэц орон тоог зохион байгуулах

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөл-д

1. Орон нутагт ИЭМДТХуулийн хэрэгжилтийг хангаж, сангийн зарцуулалтанд хяналт тавих, чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга П.Лхагважав-т

1. Орон нутагт ИЭМДТХуулийн хэрэгжилтийг хангаж, сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулан, хуулийн дагуу хариуцлага тооцож байх
2. Эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийг даатгалуулагчдад ойр, тэгш, хүртээмжтэй байхад анхаарч, хуваарилалт хийх санал гаргаж холбогдох газруудад хүргүүлж ажиллах
3. Төсвийн өөрчлөлттэй холбон эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээнд тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж, НДЕГазрын даргын 2012 оны А/367 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан даатгалын гэрээ дүгнэх журам”-ын заалтыг хэрэгжүүлэн ажиллах.
4. ЭДСангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, 3.8 заалтын шалгуур хангаагүй жорыг хүчингүйд тооцон ЭМДСангаас санхүүжилт олгохгүй байх.
5. Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар даатгуулагч, **“эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд”-д** мэдээлэл, сургалт

сурталчилгаа зохион байгуулж холбогдох хууль, заавар, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах.

Эрүүл мэндийн газрын дарга Л.Дамдинсүрэн-д

1. Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг даатгалуулагчдад ойр, тэгш, хүртээмжтэй байх нөхцлийг хангахуйцаар Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эмийн сангуудыг сонгон шалгаруулж байх.
2. Эмийн эргэлтийн сангуудын ажилтан албан хаагчдад цахим тайлан гаргах, программ хангамжид **/бар код уншигчийг ажиллуулах/** ажиллах чиглэлээр сургаж, чадавхижуулах

Нийгмийн даатгалын сан хариуцсан нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг-т

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтанд байнгын хяналт тавьж, харилцагч байгууллагуудтай сар, улирал бүр тооцон нийлэн баталгаажуулж байх.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай

Бүлэг 2. Тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээж, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцож ажилласан хэдий ч өнөөгийн орлогоороо зарлагаа нөхөж буй нөхцөлд, нэрийн данснаас тэтгэвэр тогтоох боломжгүй байна.

Монгол улс нь 1999 онд нийгмийн даатгалын тогтолцоонд шинэчлэлт хийж “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-ийг баталсан.

МУ-ын УИХ-ын 1999 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоолоор “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”⁴-ийг баталсан байна. /Хагас хуримтлалын тогтолцоонд аажмаар шилжүүлэх зорилго бүхий⁵/ Энэхүү тогтоолын зарим нэгэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор мөн оны 06 дугаар сарын 10-ны өдөр 43 дугаар тогтоолыг гаргасан байна. Тогтоолоор:

- Тэтгэврийн даатгалд даатгагдсан 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн МУ-ын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, эхний үлдэгдэл, шимтгэлийг уг дансанд тооцох, нийт даатгуулагчдад мэдээлэх ажлыг 2000 оны эхний хагаст багтаан дуусгах
- Холбогдох байгууллагаас баталж мөрдүүлэх журам, эрхийн актыг 1999 оны 10 дугаар сард багтаан батлан гаргах
- НДҮЗөвлөл болон НДаатгалын төв орон нутгийн байгууллагыг тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх үйл ажиллагааг удирдан зохицуулах, эрхлэн гүйцэтгэхэд чиглүүлж 1999 онд багтаан шинэчлэн зохион байгуулах зэрэг арга хэмжээ авахыг ЗГ-т үүрэг болгосон байна.

НДЕГ-ын даргын 2001 оны 53⁶, 2010 оны 108 дугаар тушаалаар “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны харилцааг зохицуулах журам”-ыг тус тус баталсан бөгөөд тус тушаал нь ТДШНД-ыг мэдээлэх, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, нэгдсэн тайлан гаргах, өргөдөл гаргах, зэрэг 5 хавсралтаас бүрдсэн байна.

Дэлхий нийтийн жишиг хандлагаар нийгмийн даатгалын гурван тогтолцоо байдаг байна.

1. Эв санааны нэгдлийн буюу орлогоороо зарлагаа нөхдөг хуваарилалтын тогтолцоо
2. Хагас хуримтлалын тогтолцоо
3. Бүрэн хуримтлалын тогтолцоо

Харин манай улсын тухайд: Эхний буюу нийгмийн даатгалын орлогоороо зарлагаа нөхдөг хуваарилалтын тогтолцоогоор явж байгаа юм байна. Энэхүү

⁴ Чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг УИХ-ын НБодлогын байнгын хороонд үүрэг болгосон байна.

⁵ Хагас хуримтлалын зарчимд шууд шилжих эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн таатай орчин бүрдээгүй байгааг иш үндэс болгон тэтгэврийн даатгалын хуваарилалтын одоогийн тогтолцоонд нэрийн дансны аргыг хэрэглэж, 2005 оноос хойш хагас хуримтлалын тогтолцоонд шилжих угтвар нөхцөл бүрдүүлнэ.

⁶ Энэхүү тушаалыг 2001 онд хүчингүй болгосон.

тогтолцоо нь өнөөдрийн хөдөлмөр эрхэлж буй иргэдийн шимтгэлээр ахмад настны тэтгэврийн эх үүсвэрийг бүрдүүлж байна. /*түүмээс ч эв санааны нэгдлийн тогтолцоо гэж тодотгодог байна.*/ Нэрийн дансанд шилжинэ гэдэг нь тэтгэвэр тогтоох аргад өөрчлөлт орсноос өөр зүйлгүй тул хүүхэд болоод ар гэрийнхэнд өвлүүлэх, хөрөнгө оруулалтын эргэлтэд оруулах зэрэг зүйл заалт огт байхгүй байна.

НДХ-ийн сангуудын 2013 оны санхүүгийн тайланд “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн аудитор Д.Гэрэлчулуун аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. Мөн НДСангуудын 2013 оны төлөвлөлт, зарцуулалт, дотоод хяналтанд нийцлийн аудит хийж хугацаатай зөвлөмж хүргүүлсэн болно.

2.1.Нэрийн дансыг хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу нээсэн үү?

Хөвсгөл аймгийн НДХ-ийн тухайд:

“Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны (*Нэрийн дансыг нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу тэтгэврийн даатгалд хамрагдсан, 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ.*) дагуу 2000 онд 5383 иргэний мэдээллийг нэрийн дансанд бүртгэн ажилласан байна./Хавсралт№3-аас харна уу/

1. Нэрийн дансыг хуульд заасан хугацаанаас хойш төрсөн МУ-ын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээсэн үү?

Нэрийн дансыг нээхдээ: Урьд өмнө ажиллаж шимтгэл төлж байгаагүй бөгөөд шинээр ажилд орж шимтгэл төлж эхэлж байгаа даатгуулагч, даатгалд хамрагдаагүй боловч 1995 оноос өмнө ажиллаж байсан иргэн зэргийг хамруулж нээсэн байна.⁷ /Дээр дурдсан 2 болзлыг хангасан тус аймагт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн байхгүй байна./

2. Даатгуулагчийн нэрийн данс нь дугаар давхардаагүй, даатгуулагчийн овог нэр, дансны эхний үлдэгдэл, сар бүрийн төлсөн шимтгэл, тооцсон хүү, олгосон тэтгэвэр зэрэг орлого, зарлагын талаар мэдээлэл өгөх нөхцөл хангагдсан уу?

Даатгуулагчийн нэрийн дансны дугаар нь түүний регистрийн дугаар байдаг тул давхардах боломжгүй байна, аудитын явцад тус хэлтсийн НДШСангийн бүх үйл ажиллагаа программ хангамжаар бүртгэгдэж, /тооцоологдож/ ажил олгогч болон даатгуулагчдын төлсөн шимтгэлийг хариуцсан байцаагч нар хянан баталгаажуулсны дараа 5 санд хувиаарилагдсан байна. Иймд: Тус хэлтсийн программ /*нэрийн дансны*/ зарим нэгэн даатгуулагчийн нэрийн данс руу нэвтэрч тулган

⁷ 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн бөгөөд 1995 оноос өмнө ажил хийж /хөдөлмөрийн дэвтрийг баталгаажуулсан/ байсан ажилтан албан хаагчид

баталгаажуулалт хийв. **Ийнхүү ажиллахад:** Даатгуулагчийн регистрийн дугаар түүний нэрийн дансны дугаар байгаа тул давхардах боломжгүй гэж үзэв. Гэсэн хэдий ч 12 даатгуулагчийн нэрийн дансанд тулган баталгаажуулалт хийхэд 2 даатгуулагчийн мэдээлэл буруу гарч байсан нь тухайн программаас гарч буй мэдээлэл учир дутагдалтай байгааг илэрхийлж байна. /үнэн зөв мэдээллээр хангах/

НДаатгалын хэлтсийн тухайд: Даатгуулагчийн талаар өгөх мэдээлэл /ажил олгогч болон даатгуулагчийн төлсөн шимтгэл, тооцсон хүү зэргээс бусад/ хангалтгүй байна. Учир нь: Нэрийн дансыг хариуцсан байцаагч байхгүй байгаа бөгөөд зөвхөн программ, мэдээлэл, сүлжээ хариуцсан ажилтнаар давхар хариуцуулан ажиллуулж байна. Уг ажилтан нь ХААИС-ын Байгаль хамгаалал, экологи мэргэжлээр суралцаж төгссөн тухайн чиглэлээр мэргэжил эзэмшээгүй мэргэжлийн бус ажилтан⁸ байна.

Мөн системийн дээд газар болох НДЕГ-аас нэрийн дансны мэдээлэл өгөх асуудлыг тодорхойгүй хугацаагаар хаасан байна. 2013 оны байдлаар нэрийн данснаас орлого, зарлагын мэдээлэл өгөх боломжгүй байна. **Заавал болон сайн дурын даатгуулагчийн мэдээлэх хуудас бичих үүргийг УНДЕГ-ын Бүртгэл, мэдээллийн технологи, сургалтын төв гүйцэтгэдэг байна.**

2.2. Нэрийн дансны орлогын эх үүсвэр хуулийн дагуу бүрдэж байна уу?

Нэрийн дансны орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ⁹:

- ✓ Нэрийн дансны эхний үлдэгдэл
- ✓ Даатгуулагчийн төлсөн шимтгэл
- ✓ Ажил олгогчийн төлсөн шимтгэл
- ✓ Төрөөс төлсөн шимтгэл¹⁰

Хөвсгөл аймгийн тухайд: Тэтгэврийн даатгалын шимтгэл төлөгч 836 ажил олгогчийн давхардсан тоогоор 483.9 мянган иргэний мэдээлэл 74522,5 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого бүртгэгдсэн гэж тайлагнасан байна.¹¹ Ийнхүү бүртгэгдсэн, ажил олгогч болон иргэдийн төлсөн НДШимтгэл бодитоор мөнгөн орлого болон хуримтлагдаагүй байна. **Учир нь:** Дээр дурьдсанчлан орлогоороо зарлагаа нөхөж, ахмад настны тэтгэврийн эх үүсвэр болон зарцуулагдаж байгаа юм байна.

2.2.1. Нэрийн дансны эхний үлдэгдлийг хуулийн дагуу тооцсон уу?

Нэрийн дансны гарааны үлдэгдлийн тооцохдоо НДЕГ-ын 2001 оны 53 дугаар тушаалын 3 дугаар зүйлд /*тухайн үед мөрдөгдөж байсан*/ заасны дагуу тооцож бүртгэсэн байна.¹²

2.2.2. Даатгуулагч болон ажил олгогчийн төлсөн шимтгэл бүрдсэн үү?

⁸ Төрийн албаны салбар зөвлөлийн үлй ажиллагаанд хийх аудитаар нягтлан шалгах болно.

⁹ “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйл.

¹⁰ Засгийн газрын 2008 оны 139 дүгээр тогтоол Энэ тогтоолоор нийгмийн даатгалын санд байрших ёстой мөнгийг үе шаттайгаар жил бүрийн төсөвт тусгаж барагдуулах тухай талаар агийн сайд болон нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдад Засгийн газраас үүрэг болгосон. Энэ тогтоол одоо болтол хэрэгжихгүй байна.

¹¹ НДХ-ийн мэдээлэлийн санд

¹² Даатгуулагчийн нэрийн дансны эхний үлдэгдлийг түүний нэрийн данс нээлгэх хүртэлх ажилласан, шимтгэл төлсөн хугацаа болон 1995 оноос хойшхи хугацаанд авч байсан индексжүүлсэн(итгэлцүүлээр тооцсон) хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг үндэслэн тооцно.

1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн иргэдийн ажиллаж буй байгууллага /ажил олгогч/ болон иргэд /даатгуулагч/ “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн¹³ дагуу заавал даатгуулж, НДШ төлж байна. Мөн сайн дурын даатгуулагчид дээрх хуулиар тогтоосон хувь хэмжээгээр шимтгэл төлж байна. **Иймд:** Даатгуулагчийн төлсөн шимтгэл тодорхой хэмжээгээр бүрдэж байгаа гэж үзэхээс өөр аргагүй байна. **Тухайлбал:** Хөвсгөл аймгийн хэмжээнд 2013 оны тухайд 836 ажил олгогчийн 16676,5 сая төгрөгийн НДШимтгэл төвлөрүүлэн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулж ажилласан байна.

2.2.3. Төрөөс төлсөн шимтгэл хуулийн дагуу бүрдсэн үү?

Төрөөс ямар нэгэн шимтгэл төлдөггүй, харин эрүүл мэндийн даатгалын санд төр хариуцах иргэдийн даатгалыг төвлөрүүлдэг байна.¹⁴

2.2.4. Нэрийн дансанд хууль журмын дагуу хүүгийн орлого тооцож байна уу?

НДҮЗөвлөлийн 2007 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”¹⁵-ыг баталжээ. Журмын дагуу НДҮЗөвлөлийн 2009 оны 11 болон мөн оны 13 дугаар тогтоол, 2011 оны 08 дугаар тогтоол, 2012 оны 02 дугаар тогтоолоор нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тус тус тогтоосон байна.¹⁶

Хүснэгтээр харуулбал:

Онууд	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Хүүгийн хэмжээ /хувиар/	13.0	14.0	14.0	5.0	11.0	7.0	11.1	15.8	18.7	29.8	28.3	25.4	20,6

2.3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө бодитой төвлөрсөн үү?

Тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлсэн орлогоос тэтгэвэр тавьж байгаа өнөөгийн нөхцөлд “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө”-ийг бодитой төвлөрсөн гэж үзэх боломжгүй байна. **Иймд:** Тэтгэврийн даатгалын санд хуримтлал бий болоогүй. Ажил олгогч болон заавал даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэл, төрөөс¹⁷ өгөх хувь нийлээд дээрх санг бүрдүүлж ахмад настны тэтгэврийн эх үүсвэр болон зарцуулагдаж байна гэж нийцлийн аудитаар үзэж байна.

2.3.1. Хуулинд зааснаар 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн иргэнд нэрийн данснаас тэтгэвэр тооцох эх үүсвэр бүрдсэн үү?

¹³ НДТХуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдаж байна.

¹⁴ НДХ-ийн 2013 онд төр хариуцах иргэдийн шимтгэлд 600.8 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

¹⁵ Нэрийн дансанд тооцох хүүгийн хэмжээ нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 3 жилийн дундаж цалин хөлсний дундаж өсөлтийн хувьтай тэнцүү байна. Үндсэний статистикийн газрын саналын хамт НДҮЗийн тогтоолоор жил бүр батлуулж мөрдөнө.

¹⁶ Одоогийн НДТ-ны хүрээнд шимтгэлийн орлогын хүүг хуулинд зааснаар сүүлийн 3 жилийн цалин хөлсний дундаж өсөлт дээр үндэслэн тооцдог байна.

¹⁷ ЗГазар НДаатгалд тодорхой хэмжээний өглөгтэй гэж үздэг./1960 оноос хойш төрсөн иргэдийн/

Дээрх нөхцөл байдал, үр дагавараас харахад: 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн иргэнд нэрийн данснаас тэтгэвэр олгох эх үүсвэр бүрдээгүй байна гэж үзэж байна.

2.3.2. Аудитын үед тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн бодит үлдэгдлийг тогтоосон уу?

Аудитын хугацаанд Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд мөнгөн хөрөнгийн бодит үлдэгдэл буй эсэхийг тогтоох боломжгүй байсан. Учир нь: дээр хэлсэнчлэн хуримтлал үүсээгүй даатгуулагчдын төлсөн шимтгэл одоогийн тэтгэвэр авагчдад зарцуулагдаж байна. **Мөн системийн хэмжээнд программ хангамжийн өргөтгөл хийж байгаатай холбогдон 2013 оны мэдээлэл авах боломжгүй байлаа.**

2.4. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хяналт хийгдэж байна уу?

2.4.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хяналтад тогтоосон дүрэм, журам мөрдөгдөж байна уу?

НДЕГазрын даргын баталсан удирдамжийн дагуу НД-ын хуулийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьдаг хэдий ч Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хяналтад тогтоосон дүрэм, журам мөрдөгдөж байгаа эсэхэд ямар нэгэн хяналт шалгалт хийгээгүй байна. Мөн аймгийн МХГ-ын НДаатгал хариуцсан улсын байцаагч жил бүхэн хяналт шалгалт хийсэн ч “Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай” хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгээгүй байна. Дээрх нөхцөл байдлаас харахад: “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-д ямар нэгэн хяналт, шалгалт хийгдээгүй байна гэж нийцлийн аудитаар үзэж байна.

Өнөөгийн тогтолцоогоор ЗГазар шимтгэл төлж буй даатгуулагчдын мөнгийг өсгөхгүй, өмнөх үеийнхэнд нь тэтгэвэр болгоод өгч байна. Гэтэл: 2010 оноос 4 хүүхэд төрүүлсэн, хуулиар заасан ажилласан жил нь гүйцсэн болон цэргийн ажилтан албан хаагчид аль хэдийн тэтгэвэрт гарч өндөр насны тэтгэврээ авч эхэлсэн байна. Хөвсгөл аймгийн тухайд: 2013 оны байдлаар 1960 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш төрсөн 253 иргэн өндөр насны тэтгэвэр авч байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлсэн орлогоос тэтгэвэр тавьж байгаа өнөөгийн нөхцөлд “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө”-ийг бодитой төвлөрсөн гэж үзэх боломжгүй байна. **Иймд:** Тэтгэврийн даатгалын санд хуримтлал бий болоогүй. Ажил олгогч болон заавал даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэл, төрөөс¹⁸ өгөх хувь нийлээд дээрх санг бүрдүүлж, ахмад настны тэтгэврийн эх үүсвэр болон зарцуулагдаж байна гэж нийцлийн аудитаар үзэж байна.
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн хоёр дахь заалтад “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэж заасан байдаг. Засгийн газар энэ заалтыг зөрчсөөр ирсэн бөгөөд цаашид ч үл тоомсорлох янзтай. Энэ байдлыг өөрчлөхгүй бол иргэдийн нэрийн дансан дахь мөнгө төсвийн цоорхой нөхсөөр, эргээд тэтгэвэр авах гэхээр хоосорсон байх аюул хэдийнээ хаяанд ирсэн байна.
- Одоогийн хуваарилалтын тогтолцоо нь тухайн жилийн шимтгэлийн орлогоор тэр жилийнхээ тэтгэвэрийг санхүүжүүлж байна. Төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн тэтгэвэр тэтгэмжийн хөрөнгийг улсын төсвөөс нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх ёстой боловч бүрэн хэмжээгээр төвлөрүүлэхгүй байгаа нь тэтгэврийн даатгалын сан алдагдалтай ажиллах, алдагдал өсөн нэмэгдэх нь тодорхой байна.

¹⁸ ЗГЗар НДатгалд тодорхой хэмжээний өглөгтэй гэж үздэг./1960 оноос хойш төрсөн иргэдийн/
УАГ-НАГ/2014/09-НА/-ХӨААГ

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

НДЕГазрын дарга Ц.Уртнасанд

1. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”, түүнийг дагаж мөрдөх журмыг эргэн харж, тэтгэврийн даатгалын тогтолцоог өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх
2. “Тооцоолох төв”-ийн программ хангамжийг сайжруулан, даатгуулагчдыг мэдээллээр хангах асуудлыг боловсронгуй болгох

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны нэгдсэн судалгаа

2012 оны байдлаар

	Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Эхний үлдэгдэл	Даатгуулагч төлсөн шимтгэл	Ажил олгогчийн төлсөн шимтгэл	Төрөөс төлсөн шимтгэл	Нэрийн дансны орлогод тооцсон хүү	Бүгд дүн
	Хөвсгөл аймаг	91 769 324 722.7	3 016 478 912.3	3 309 493 118.6		20 207 631 130.0	118 302 927 883.6
	Дүн	91 769 324 722.7	3 016 478 912.3	3 309 493 118.6	-	20 207 631 130.0	118 302 927 883.6

Хөвсгөл аймгийн НДХ-ийн 2013 онд банк тус бүрээр олгосон тэтгэврийн дүн

№	Сумдын нэр	Нийт олгосон тэтгэврийн дүн	Хүний тоо /өссөн/	Хаан банк	Төрийн банк	Капитал банк	Хас банк
1	Алаг-эрдэнэ	644 260 711	3 547		644 260 711		
2	Арбулаг	768 495 483	4 221	768 495 483			
3	Баянзүрх	855 617 171	4 711		855 617 171		
4	Бүрэнтогтох	903 327 052	4 910	903 327 052			
5	Галт	1 086 293 473	6 067	1 086 293 473			
6	Жаргалант	1 107 223 573	6 157		1 107 223 573		
7	Их-уул	1 069 666 180	5 648		1 069 666 180		
8	Рашаант	883 936 729	4 744		883 936 729		
9	Рэнчинлхүмбэ	1 063 615 343	5 781		1 063 615 343		

10	Тариалан	1 584 033 313	8 501		1 584 033 313		
11	Тосонцэнгэл	918 301 560	5 054		918 301 560		
12	Төмөрбулаг	871 727 793	4 850		871 727 793		
13	Түнэл	769 831 317	4 256	769 831 317			
14	Улаан-уул	933 435 105	5 094		933 435 105		
15	Ханх	540 276 362	2 794		540 276 362		
16	Хатгал	856 522 125	4 366	856 522 125			
17	Цагааннуур	353 436 004	1 872		353 436 004		
18	Цагаан-уул	1 054 077 006	5 868	1 054 077 006			
19	Цагаан-үүр	728 835 508	3 917		728 835 508		
20	Цэцэрлэг	1 238 592 292	6 618		1 238 592 292		
21	Чандмань-өндөр	741 161 237	4 126		741 161 237		
22	Шинэ-идэр	883 989 069	4 841	883 989 069			
23	Эрдэнэбулган	756 480 587	3 901	756 480 587			
24	Сумдын дүн	20 613 134 993	111 844	7 079 016 112	13 534 118 881	-	-
25	Мөрөн /Хэлтэс/	11 064 558 141	53 951	5 302 337 613	4 111 073 072	346 217 400	1 304 930 056
26	Бүгд дүн	31 677 693 134	165 795	12 381 353 725	17 645 191 953	346 217 400	1 304 930 056

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчийн судалгаа

№	Үзүүлэлтүүд	Онууд								
		2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	Тэтгэвэр авагчдийн тоо	14 026	15 434	15 490	13 905	13 894	13 952	13 984	13 996	13 945
2	Зарцуулсан хөрөнгө /сая. төг/	5 558.5	6 946.9	9 768.2	13 587.5	13 603.4	14 693.1	17 918.0	28 406.7	31 677.7
3	Нэг хүнд ногдох тэтгэвэр /сард дундаж төгрөгөөр/	41731	43619	68124	81730	81730	106247	106247	181922	189250
	Үүнээс: 2010 оноос тэтгэвэр тогтоолгосон иргэдийн судалгаа /1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн иргэд хамрагдана/									
№	Үзүүлэлтүүд	Онууд								
		2010		2011		2012		2013		
1	Тэтгэвэр авагчдийн тоо	84		128		197		253		
2	Зарцуулсан хөрөнгө /сая. төг/	44.8		92.2		174.4		249.7		
3	Нэг хүнд ногдох тэтгэвэр /сард дундаж төгрөгөөр/	110464		218545		220387		233256		

Хавсралт №03

**Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны судалгаа
2000-2012 он**

/Төгрөгөөр/										
Он	Даатгу улагчд ын тоо	Шинэ	Эхний үлдэгдэл	Хөдөлмөрийн хөлс	Шимтгэл	ҮА-зардал	Бүртгэсэн шимтгэл	Эхний үлдэгдлийн хүү	Бүртгэсэн шимтгэлийн хүү	Эцсийн үлдэгдэл
2000	5 383	5 383	8 448 054 666,4	1 762 927 072,5	291 817 576,6	11 672 292,7	280 145 283,9	1 098 247 106,5	36 418 886,7	9 862 865 943,5
2001	6 144	761	9 862 865 943,5	2 050 926 684,2	343 931 184,8	13 755 512,7	330 175 672,1	1 380 801 231,8	46 224 593,9	11 620 067 441,4
2002	6 870	726	11 620 067 441,4	2 517 481 926,7	420 934 108,8	16 797 106,6	404 137 002,2	1 626 809 441,5	56 579 180,1	13 707 593 065,2
2003	7 534	664	13 707 593 065,2	2 986 716 615,2	492 787 557,6	19 605 710,0	473 181 847,7	685 379 653,0	23 659 092,2	14 889 813 658,1
2004	8 219	685	14 889 813 658,1	3 728 997 510,1	617 895 848,8	24 656 373,5	593 239 475,3	1 637 879 502,0	65 256 342,1	17 186 188 977,4
2005	9 030	811	17 186 188 977,4	4 799 853 729,2	799 967 298,9	31 845 248,9	768 122 050,0	1 203 033 228,1	53 768 543,3	19 211 112 798,8
2006	9 797	767	19 211 112 798,8	6 701 068 616,4	1 105 007 083,1	43 917 733,5	1 061 089 349,6	2 132 433 520,2	117 780 917,6	22 522 416 586,2
2007	10 695	898	22 522 416 586,2	10 608 514 073,2	1 740 659 528,8	69 013 915,0	1 671 645 613,8	3 558 541 820,2	264 120 006,7	28 016 724 026,9
2008	11 789	1 094	28 016 724 026,9	20 330 588 991,1	2 512 370 828,0	99 597 202,1	2 412 773 625,9	5 239 127 392,5	451 188 667,7	36 119 813 713,0
2009	12 899	1 110	36 119 813 713,0	23 200 628 175,4	2 882 771 673,5	114 327 658,2	2 768 444 015,3	10 763 704 485,9	824 996 316,2	50 476 958 530,4
2010	13 933	1 034	50 476 958 530,4	27 098 514 372,7	3 392 349 087,3	134 535 392,2	3 257 813 695,1	14 284 979 263,5	921 961 275,3	68 941 712 764,3
2011	15 190	1 257	68 941 712 764,3	35 180 781 565,0	4 414 567 368,7	175 000 448,9	4 239 566 919,7	17 511 195 041,5	1 076 849 997,2	91 769 324 722,7
2012	16 361	1 171	91 769 324 722,7	52 591 036 675,3	6 587 507 686,7	261 535 655,8	6 325 972 030,9	18 904 480 892,1	1 303 150 237,9	118 302 927 883,6

Холбогдох байгууллагын санал


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**
67123 Мөрөн Хамгаалалтын
Утас/Факс: 70362700

2014.06.26 № 174
талай 2014.06.19-ны № 02/201-т

**ҮНДЭСНИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг
хавсралтаар гаргаж хүргүүлэн.

ДАРГА  ПЛХАГВАЖАВ

GS 00224

Холбогдох байгууллагын санал

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ		
2014.08.27		Мөрөн
№	Зөрчлийн товч утга	Тайлбар оруулах санал /тайлбар/
1.	Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн даатгалын орон тосны бус зөвлөл 2012 оноос хойш хурагдаагүй, ямар нэгэн асуудал шийдвэрлээгүй байна.	ИЭМДТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлд орон тосны бус салбар зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг даатгалын зөвлөл батална” гэсэн заалт нь НДҮЗөвлөлийн бүрэн эрхийн асуудал учир НДХ-ийн эрх үүрэгт хамаарахгүй болно./Дээрх хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т НДҮЗ-нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан даатгалын зөвлөлийн дарга, гишүүдийг томилогч даатгалын зөвлөлийн ажиллах журмыг талуудын саналыг үндэслэн батлана..../
2.	НДҮЗөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан ЭМДСангийн зарцуулалтыг тодотгосон төсвийн дагуу эмийн сангуудтай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна. Тухайлбал: 18 сумын эмийн эргэлтийн сан, хувийн хэвшлийн 4 эмийн сантай хийсэн гэрээ батлагдсан төсвөөсөө 800,0 мянган төгрөгөөс 18000,0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	НДҮЗ-ийн 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн тодотголын дагуу тухайн эмийн сангуудын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон болно. Угирал бүр тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т хүргүүлдэг болно.
3	ЭМДСангийн хөрөнгөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагууд болон даатгуулагчид зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн эмийн сангуудтай байгуулсан гэрээг НДЕГазрын даргын 2012 оны А/367 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу дүгнэгдээгүй байна. Тухайлбал: Журмын 3.1-д заасан томилогдсон баг, бүрэлдэхүүнээр гэрээ дүгнээгүй байна.	НДХэлтсийн даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг гэрээний хэрэгжилтийг дүгнэхдэг үйл ажиллагааны төрлөөрөө тус тусдаг үнэлгээ хийдэг. Цаашид нэгдсэн багийн зохион байгуулалтаар үнэлгээг хийх ажиллах болно.
4	Журмын дагуу гэрээний биелэлтийг 58 оноогоор дүгнүүлсэн Хатгал тосгоны СДЗ-тай байгуулсан гэрээг цуцлаагүй байна.	Хатгал тосгоны СДЗ-тай байгуулсан гэрээний тухайд Журмын 5.1.4-т заасны дагуу гэрээ цуцалж болох байсан боловч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг

		хангах үүднээс ажил сайжруулах “Албан шаардлага” хүргүүлэн ажиллаж байна. Нэр бүхий сумдын эмийн зргэлтийн сангийн тухайд мөн “Албан шаардлага” хүргүүлж, хэрэгжилтийг дотоод хяналтын хуваарийн дагуу шалгаж байгаа тул аудитын дүгнэлтэнд харгалзан үзнэ үү.
5	Аймгийн нэгдсэн эмнэлэг 2014 онд хувийн эмнэлгүүдтэй үйл оношийн шинжилгээ хийх тухай хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээнд үйл оношийн тасалт багажийн болон лабораторийн шинжилгээ хийлгэсэн тохиолдолд нэгжийн өртгөөр шинжилгээний төлбөр авах тухай заасан байна. Гэсэн хэдийн боловч аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл оношийн тасгаар хийгдсэн шинжилгээний төлбөрийг ЭМДСангаас нэхэмжлэн авч байна. Хувийн эмнэлгүүдийн хийлгэсэн лабораторийн шинжилгээний төлбөрийн тооцоог гаргаж холбогдох эмнэлгээр төлүүлж ЭМДСанд буцаан төлүүлэх төлбөрийн актыг Нэгдсэн эмнэлгийн дарга С.Чапнаадоржид тогтоож байна.	Нэгдсэн эмнэлэг ХХЭхооронд ийм гэрээ байгуулсан тухай манайд мэдэгдээгүй бөгөөд хяналтаар эмнэлэг хооронд төлбөр хийсэн зөрчил илрээгүй болно. Цаашид анхаарч ажиллах болно.
6	Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 418 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн 8 эмнэлгийг шалгаруулж Эрүүл мэндийн яаманд үр дүнг тайлагнасан боловч магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгийг сонгон шалгаруулсан байна.	НДЕГазрын харьяа ЭМДГазрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 04-ны өдрийн 1/34 албан тоотоор магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эмнэлгүүдэд даатгуулагчдад үзүүлсэн тусламж үйлчилгээний зэрдлын төлбөрийг гүйцэтгэж байх тухай чиг өгсөн тул ЭМДдаатгалаас санхүүжилт олгосон болно.
7	Эрүүл мэндийн даатгалын сангаас ИЭМДТхуулийн 7.8 заалтын дагуу 2013 онд 4012.8 мянган төгрөгийг урамшууллыг аймгийн нэгдсэн эмнэлэгт олгохоор гэрээ хийж, 168 даатгуулагчийн 3696.0 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсныг 4012.8 төгрөгийн санхүүжилт буюу гүйцэтгэлээс 316.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.	Урамшууллын зэрдлын санхүүжилтийг тайлант оны эцэст урдчилан олгож гүйцэтгэлийг хянаж олгоход зөрүү гарсан тул ЭМД-ын санд буцаан төлүүлэхээр акт тогтоосон болно.

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар

Асуудал 4: Тайлангийн 1.1.2 хэсэгт өөрчлөлт оруулав.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ХӨВСТӨЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас: 70383793

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА С.ЧАГНААДОРЖ ТАНАА

2014.06.30 № ҮАТ-ЗАТ/2014/09-НА-ААТ-01/39

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Аймгийн аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Эрүүл мэндийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн байдал, үйл ажиллагаа” нийцлийн аудит хийхэд: Аймгийн нэгдсэн эмнэлэг хувийн эмнэлгүүдтэй “Үйл оношийн тасагт багажийн болон лабораторийн шинжилгээ хийлгэсэн тохиолдолд нэгжийн өртгөөр шинжилгээний төлбөр авах тухай” хамтран ажиллах гэрээ байгуулсан нь “ЭМДСангаас санхүүжих тусламж үйлчилгээний төлбөрийн арга, санхүүжилтийн хэмжээг тооцох журам”-ын 5 дугаар заалтыг зөрчсөн зөрчил илэрлээ.

Иймд: Монгол улсын “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 12-т заасан (...аудитын явцад илэрсэн төлбөр,зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих...) гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй үйл оношийн шинжилгээний төлбөр авах талаар байгуулсан гэрээ эргэн харж өөрчлөн 2014 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор Аймгийн Аудитын газарт албан ёсоор хариу мэдэгдэхийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга С.Чагнаадоржид -д даалгаж байна.

ШААРДЛАГА БИЧСЭН: АУДИТЫН МЕНЕЖЕР



Г.ЭРДЭНЭЧИМЭГ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг,
Утас, факс: 70383793

2014.06.30 № 02/211
ТӨМӨЙ _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу "Эрүүл мэндийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн байдал, үйл ажиллагаа"-нд хийсэн нийцлийн аудитын тайланг хүргүүлж байна.

АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ

973417

My.doc A5
07 208